



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/570

Хэрлэн сум


“Зүүн бүсийн түншлэл 2023”
үзэсгэлэн зохион байгуулахад
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3 дахь заалт, Улсын Их Хурлын 2021 оны “Хот, хөдөөгийн сэргэлт” 106 дугаар, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Нээлттэй-Хэнтий” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай 9 дүгээр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 20 дугаар хуралдааны “Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” 02 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүс нутгийн бизнес эрхлэгчид, малчид, тариаланчдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчилан таниулах, түгээн дэлгэрүүлэх, бизнесийн түншлэлийг тогтоох, бүтээгдэхүүний чанар, стандарт, экспортын чадамж ба боломжийг дээшлүүлэх, бүс нутгийн хэмжээнд брэнд бүтээгдэхүүнийг шалгаруулах зорилготой “Зүүн бүсийн түншлэл 2023” үзэсгэлэн зохион байгуулахад зориулж Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Хэнтий аймаг дахь салбар танхимд 20,000,000 (хорин сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ